

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Манай хамт олон энэ долоо хоногт завгүй ажиллалаа. Бямба гарагт багш сурагчид, эцэг эхчүүд хөл бөмбөгийн талбайг цэвэрлэж ЭББ-хэн тэдэнд хөнгөн зуушаар үйлчиллээ. Энэ өдөр цаг агаар сайхан дулаахан байлаа. Ням гарагт манай сургуулийн 10-р ангийн сурагчид санаачлан багш Ms. Lohman-удирдан “Усны Төлөө Гүйцгээ” арга хэмжээг анх удаагаа амжилттай зохион байгуулж олон нийт идэвхтэй дэмжиж оролцлоо. Энэ арга хэмжээнд гүйж, алхаж, тусалж, дэмжиж, хандив өргөж оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

Энэ долоо хоногт бага сургуулийн хамт олон дэлхийн өдрийг тэмдэглэж олон арга хэмжээ зохиолоо. Тэд орчноо цэвэрлэж, 2-р ангийнхан 1000 хальсан уут цуглуулж сурч мэдсэн зүйлээ эцэг эхчүүд та бүхэнтэй хуваалцах болно. Хальсан уут цуглуулах аянд хандив өргөж оролцсон бүх хүмүүст баярлалаа. 4 сарын 22-ны Пүрэв гарагт бид сургууль дээрээ Дэлхийн өдрийг тэмдэглэж ногоон өнгийн хувцас өмсөж эх дэлхийгээ хайрлах арга хэмжээнд өөрсдийн хувь нэмрийг оруулсан бөгөөд энэ арга хэмжээнд оролцсон бүх багш сурагчиддаа талархал илэрхийлье.

Сургуулиас болон сургуулиас гадуур зохиогдож байгаа арга хэмжээнд манай багш сурагчид идэвхтэй оролцож байгаад бид баяртай байдаг. Хэрвээ та бүхэнд бидний тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа бол бидэнд мэдэгдээрэй. Манай бэлтгэл ангиас 12-р ангийн нийт сурагчид та бүхний зохион байгуулах ажилд оролцож дэмжиж ажиллахдаа баяртай байх болно.

Манай сургуулийн охид, хөвгүүдийн хөл бөмбөгийн баг тамирчид Хятад улсад зохиогдох ACAMIS хөл бөмбөгийн тэмцээнд оролцохоор явсан. Тэдний амжилтын талаар бид ням гарагт ирэхээр нь та бүхэнд мэдээлэх болно.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Захирал Greg Rayl

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

4 сарын 18-ны Ням гарагт зохиогдсон “Усны Төлөө Гүйцгээ” арга хэмжээ маш амжилттай болж өнгөрлөө. Энэ арга хэмжээг анх удаагаа санаачлан зохион байгуулсан 10-р ангийн сурагчиддаа баяр хүргэе! Бид цаашид энэ арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулах болно. Ms. Lohman энэ арга хэмжээг амжилттай удирдан зохион байгуулж сургуулийн нийт хамт олон багш ажилчид, сурагчид, эцэг эхчүүд, олон нийт дэмжиж идэвхтэй дэмжиж оролцлоо. Хатагтай Цацрал энэ өдөр ажиллах хамгаалалтын албаны хүмүүсийг ирүүлж тусалсан бөгөөд манай багш ажилчид, эцэг эхчүүд, сурагчид бүгд энэ арга хэмжээнд оролцож зарим нь гүйж, зарим нь арын албанд сайн дураар тусалж ажилласан.

Бямба гарагийн цэвэрлэгээ сайн хийгдэж манай талбай хог, шорооноосоо салсан харагдаж байна. Mr. Ricketts болон багш сурагчид, эцэг эхчүүд бямба гарагт сайн ажиллалаа. ЭББ-ийн хамт олон тэднийг хооллохоор өглөө эрт ирсэн байсан. Ногоон Пүрэв гарагийн талаар та бүхэн хүүхдүүдээсээ асуугаарай. Тэд байгаль орчноо хамгаалах талаарх мэдээлэлийг та бүхэнтэй хуваалцана гэдэгт би итгэлтэй байна. Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлэнгээ Хятадын Qingdao хотноо ACAMIS хөл бөмбөгийн тэмцээнд оролцож байгаа манай баг тамирчдад амжилт хүсээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

Сурагчдын Зөвлөлөөс

4 сарын 29-ний Пүрэв гарагт завсарлагааны үеэр сурагчдын зөвлөл жигнэмэгийн худалдаа зохион байгуулна. Энэ үеэр амттай жигнэмэгүүд болон хөнгөн зууш худалдаалах болно. Жигнэмэгийн худалдаанаас олсон орлогыг ОУДС-ийн төгсөлтийн үдэшлэгийн арга хэмжээнд хандивлах болно. Та бүхэн амттан худалдан авч бидэнд хандив оруулаарай.

**Усны Төлөө Гүйцгээ
2010 оны Анхны Гүйлт**

Өнгөрсөн Ням гарагт Усны Төлөө Гүйцгээ арга хэмжээнд оролцсон бүх хүмүүст баярлалаа. ОУДС болон бусад Англи хэл дээр сургалт явуулдаг сургуулиудын хамт олон мөн Улаанбаатар хотын иргэд

манай сургууль дээр 9 цагт хүрэлцэн ирж нээлтийн арга хэмжээнд оролцож усны төлөө 6 км, 2 км-н зайд гүйцгээлээ.

Үдээс хойш манай арга хэмжээнд Монгол улсын Гавъяат жүжигчин дуучин Далантай, Киви хамтлаг ирж ая дуугаа өргөлөө. Усны Төлөө Гүйцгээе арга хэмжээ амжилттай болж өнгөрлөө. 6 км-т гүйсэн хүмүүс ядарсан хэдий ч усны төлөө гүйсэндээ баяртай байлаа. Энэ зайнд өдөр бүр алхаж олон литр ус авч ирдэг хүмүүсийн талаар та нар бодоод үзээрэй. Усны хомсдолтой газрын хүмүүс өдөр бүр ундны усаа авах гэж 6 км зайг туулдаг.

Энэ гүйлтийн арга хэмжээгээр дамжуулж бид ундны усаа шууд дэргэдээсээ л авчихдаг их азтай хүмүүс гэдгээ ойлгосон байх гэж найдаж байна.

Усны Төлөө Гүйцгээе арга хэмжээний үеэр бид нэг сая долоон зуун мянган төгрөгийн (1, 700.000) хандив цуглуулсан. Бид энэ хандиваа Habitat for Humanity төрийн бус байгууллагад өгөх болно. Энэ ТББ манай хандивыг Монголд усны төсөл хэрэгжүүлэхэд зарцуулах болно. Энэ арга хэмжээ та бүхний дэмжлэгтэйгээр маш амжилттай зохиогдлоо. Та бүхэн манай арга хэмжээнд ирэх жил бас оролцоно гэдэгт бид найдаж байна. Та бүхэнд баярлалаа.

10-р ангийн сурагчид

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Ням гарагт Усны Төлөө Гүйцгээе арга хэмжээнд оролцсон бага сургуулийн хамт олондоо баярлалаа. Энэ арга хэмжээ бидний судалж байгаа байгаль орчны сэдэвтэй нягт холбоотой зүйл байлаа. Эх дэлхий байгаль орчноо хайрлаж хамгаалах тал дээр сурагчид маань их зүйлийг сурч мэдлээ. 2-р ангийн сурагчид айл өрхүүд дунджаар хэдэн ширхэг хальсан уут хэрэглэдэг талаар судалж байгаа бөгөөд тэд нэмж хальсан уутнууд цуглуулах хэрэгтэй байна. Та бүхэн 2-р ангийн сурагчдад хальсан уутнууд авчирч өгөөрэй.

Өдөрлөг: “Charlottes Web” тоглолтоо 4F ангийн сурагчид өнгөрсөн долоо хоногт бидэнд сонирхуулсан. Тэд тоглолтын хувцсаа өөрсдөө хийсэн. Сурагчид өөрсдийн зохиосон шүлгээ уншиж сонирхуулсан бөгөөд сайн найз байна гэдэг нь ямар утгатай болохыг бусадтайгаа хуваалцсан.

Хамгийн сайхан аялал: 3-р ангийн сурагч Mackenzie Wilson

“3-р ангийн сурагчид Даваа гарагт дуурийн театрт очиж Universal Best Songs фестивалд зориулж дуулж бүжиглэлээ. Chaandmon болон түүний хамтлагийхан хөгжмөө тоглож бид дуулж бүжиглэсэн. Эхний дуун дээр бид бүжиглээгүй, харин хоёр, гурав дахь дуун дээр бид бүжиглэсэн. Их хөгжилтэй сайхан байсан. Тэнд бас утаа гаргадаг машин байсан бөгөөд тайзан дээр утаа гарч утаа нь Chaandmon – ы дүү Sky-н толгойг давж байсан. Chaandmon –ы хамтлаг Долоо Хагас гэдэг нэртэй. Тэнд 85 хүн дуулах гэж хүлээж байсан. Их олон хүн байсан учраас бид тоглолтыг нь үзэж чадаагүй. Тэдний тоглолт UBS телевизээр гарна.”

5-р ангийн Үзэсгэлэн

Ирэх долоон долоо хоногийн туршид 5-р ангийн сурагчид PYP үзэсгэлэндээ бэлтгэх болно. Энэ Үзэсгэлэн нь PYP хөтөлбөрийн төгсөх ангийн сурагчдын хувьд хамгийн чухал төсөл байдаг. Үзэсгэлэнд бэлтгэх явцдаа сурагчид маань нэг орныг болон дэлхий нийтийг хамарсан асуудлыг тодорхойлж судлан шийдвэр гаргах замаар хамтран ажилладаг бөгөөд энэ нь томоохон судалгааны ажил байдаг.

Энэ жилийн PYP хөтөлбөрийн Үзэсгэлэн “Бид Эх Дэлхий Дээр Хэрхэн Хамтарч Амьдрах Вэ” сэдвийн дор зохиогдоно. (бид бүгдээрээ энэ дэлхий дээрх нөөц баялгийг бусад хүмүүстэй болон амьд ертөнцтэй хэрхэн хуваалцаж бид ямар үүрэг хариуцлага хүлээх вэ гэдэг талаар судлах болно)

Гол Сэдэв: Би Өөрчилж Чадна

Үзэсгэлэнгийн Гала үдэш 6 сарын 8-нд, Үзэсгэлэн 6 сарын 9-нд болно. Энэ үеэр 5-р ангийн сурагчид маань бусадтай өөрсдийн туршлага, хийсэн ажлынхаа тайланг хуваалцах болно. 5-р ангийн

сурагчдын хийсэн ажлын бүтээл энэ өдрүүдэд үзэсгэлэнд тавигдаж тэд презентаци хийж, тоглолтоо сонирхуулна. 5-р ангийн сурагчид болон тэдний эцэг эхчүүдэд зориулж 4 сарын 28-ны Лхагва гарагт үзэсгэлэнгийн талаарх мэдээлэл хийх болно. Дэлгэрэнгүй мэдээллийг та бүхэнд удахгүй хүргэнэ.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins